

# Манмин Мэдээ

№ 78 2019 оны 11 сарын 24

## Дагалдах тэмдэг гайхамшгаар авралын зар түгээв!

Пакистан, Венесуел, Тайланд зэрэг улсад пастор удирдагчдын  
семинар болон эдгэрэл ивээлийн цуглаан



Манай сүм өнгөрсөн 37жилийн турш аврал зар түгээх, дэлхий даяар сайн мэдээний үйлсд хамаг хүчээ зориулж ирсэн бөгөөд, пасторууд ахлагч нар, И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-аар гадаад өнцөг булан бүрт эдгэрлийн цуглаан явагдаж, Ариун Сүнсний хүчит үйлээр маш олон хүмүүс эдгэрч, дэлхийн даяарх үй олон хүмүүсийг Эзэний өвөр рүү удирдсаар байна.

Саяхан Пакистан, Шри-Ланка, Венесуел, Аргентин, Тайланд зэрэг улсад эдгэрлийн цуглаан, пастор удирдагчдын семинар болж, тэр болгонд дагадах тэмдэг

гайхамшигаар авралын зарыг хүчтэйгээр түгээж байна.

Гил Тэ шиг пастор (Дейжон Манмин цуглааны хариуцагч) нь 8-р сарын 26наас 9-р сарын 7ныг хүртэл лалын шашинтай Пакистан болон буддын шашинтай Шри-ланкад пастор удирдагчдын семинар, болон эдгэрлийн цуглааныг удирдан явууллаа.

Жан Жон ён пастор (Колумба Манмин сүмийн хариуцагч) нь 9-р сарын 9нөөс 15ныг хүртэл Венесуелийн нийслэл Каракас хот, мөн Ингүн миранда муж, Сулиа мужид 9-р сарын 24-29нийг хүртэл Аргентинд эдгэрлийн цуглааныг удирдан явууллаа.

Мөн 9-р сарын 4нөөс 11нийг хүртэл И Сон чил пастор (Масан Манмин цуглааны хариуцагч), төв сүмийн дэд пастор Им Хаг ён пастор Тайланд Банкей цуглаан, Хайрын хүч цуглаан, Бангкок хөгжлийн бэрхшээлт иргэдийн цуглаан тус бүрд эдгэрлийн цуглааныг удирдан явууллаа.

Ялангуяа Пакистанд болсон цуглаанд тал бие нь мэдээгүй болсон нэгэн хүн гар алчуурын залбирал аваад тэр даруй босож алхдаг болж, алхаж чадахгүй байсан Инас бсартай хүүхэд анх удаа алхаж явдаг болсон юм. Мөн нүдний шилгүй бол урдахаа огт хардаггүй хүн шилгүй ч

байсан хардаг болох зэрэг гайхамшигт тэмдгүүд гарсаар байв.

Тэгвэл Венесуелд болсон пастор удирдагчдын семинарт оролцогчид “Ариун сайн мэдээ бол Венесуелийг өөрчилж чадах Бурханы үг юм” гэцгээж, цаашид хамтдаа үйлчлэхийг хүсэн 110 гаруй хамтарсан цуглаан хамтрахаар нэгдэцгээлээ.

Үйлс номын 19-р бүлэгт гардаг Элч Паулын биенээс алчуур бүсийг авч, өвчтэй хүмүүст хүргэхэд тэдний өвчин нь зайлж, гайхамшигт эрх мэдэлт хүч бий болсон тухай библид тэмдэглэгдсэн байдаг юм.



Эрх мэдэлт хүчний нөлөөг анагаах ухаанаар нотлодог WCDN (Дэлхийн Христэд итгэгч эмч нарийн холбоо)

WCDN ямар нэг урсгал чиглэл хамааралгүй дэлхий даяарх Христчин эмч нарын цугларалт бөгөөд Бурханы хүч чадлаар эдгэрсэн төрөл бүрийн гэрчлэл баримтуудыг анагаах ухааны үүднээс батлан нотлох зорилготой ба 2004 онд анх байгуулагдсан юм. АНУ, Энэтхэг, Австраль, Филиппин, Итал, Норвеги, Мексик, Болгар, зэрэг улсуудад нэгдсэн христэч эмч нарын конференц зохион байгуулан, эмэн эмчилгээ, мэс засалд оролгүй Бурханы эрх мэдэлт хүч чадлаар эдгэрсэн гэрчлэлийн материалуудыг дагалдах эмнэлэгийн магадлагаатай хамт ил гарган илтгэл тавьж, библийн үг үнэн болохыг баталсаар ирсэн юм. Одоо Солонгост дах төв байгууллага болох болон дэлхийн 18 оронд салбар байгууллагад шилдэг эмч нар Бурханы хүч чадлыг тунхагласаар байна.

WCDN 15 дахь удаагийн Польшид болсон конференцд тавигдсан эдгэрлийн материал

“Тархины цус харвалтын улмаас гэмтсэн уураг тархи хэвийн болсон нь”

Им Ён шин халамжлагч (57 нас, 2-р их бүлэг 15-р хэсэг)



Хэдийн 14н жилийн өмнөх явдал юм. Нэгэн өдөр толгой маш хүчтэй өвдөж байсан ба дараа дахин хүчтэй өвдөн өглөөний цай бэлдэж байх зуур ухаан алдаж унаад эмнэлэгт хүргэгдсэн юм. Тэнд очоод тархинд цус харвасан болохыг мэдсэн юм.

Эмч зулайны зүүн тал болон баруун тархинд цус алдсан амьдрах найдваргүй, амьдарвал насан туршдаа биеийн саажилт болон хэл ярианы бэрхшээлтэй болно гэсэн юм.

Хичнээн ухаангүй, хөл гар минь мод шиг хөшсөн байдалтай эмнэлэгт хэвтэж буй миний төлөө гэр бүлийнхэн


минь нулимсаараа залбирч өгсөн юм. Тэгээд тэднийхээ тусламжтай түргэн тэргээр И Жей руг тэргүүн пастор дээр очин залбирал авсаны дараа талархалтай нь ухаан орсон юм.

Хоёр дахь удаагаа залбирал авсаны дараа зүүн талын саажилт тавирч, гуравдахь удаа залбирал авахад алхдаг болсон ба гараараа юм барьдаг болсон юм.

Би Эзэнд улам ойртон зуурч залбирах тусам Бурхан өдрөөс өдөрт эрүүл эрч хүчтэй болгож байлаа. Тэгээд 9н сарын дараа СТ болон MRI зураг авахуулахад эмч үзээд “Бүх зүйл

хэвийн болжээ” гэсэн гайхамшигтай сайхан мэдээ сонссон юм. Халлелүя! Эзэний нэмж өгсөн амьдралыг би талархалтайгаар амьдарч байна.

MRI зураг



Их хэмжээний цус харвалтын улмаас баруун зүүн тархины ийм байсан ч залбирал авсаны цус алдсан байдал хэвийн болсон байдал.

# “Манминтай уулзсан явдал миний амьдралын маш том ерөөл юм”



WCDN Мексик салбар байгууллагын дарга, эмэгтэйчүүдийн эмч Даниел Фуентос доктор

Би WCDN АНУ дахь захирал Армандо Пинэда поктороор дамжуулан WCDN-ны тухай мэдсэн юм. Түүний дараа Кения нээгдсэн 9дэх удаагийн WCDN конференцд урилгаар оролцсон бөгөөд энэ үйл явдал миний амьдралыг бүрэн өөрчилсөн юм.

Олон хүмүүс Бурханы хүч чадлаар эдгэрсэн гэрчлэлүүдийн маш нарийн тодорхой нотолгоотой хамт дамжуулж буй WCDN-н үйлчлэл надад том цохилт болсон юм. Зөвхөн Бурханы үгийг дамжуулах бус Бурханы хүч чадлыг анагаах ухааны баримт нотолгоотой хамт үзүүлж өгч байгаа Бурхан одоо ч бидний дунд ажилласаар байгаа гэдгийг мэдүүлж өгсөн юм. Тэр үеэс би Мексик WCDN конференцийг бэлдэж эхэлсэн ба Манминтай хамтдаа маш олон гайхалтай бас аз жаргалтай цагуудыг өнгөрөөсөн юм.

Бурхан И Жей руг пастороор дамжуулан эдгээрийг үйлдэж байгаа нь түүний сайхан сэтгэлтэй, ариун байдлын үлгэр болсон амьдралаас хараад л Бурханы сонгосон хүн гэж бодож байна. Библид Эзэнд итгэгч нь Есүсийн хийдэг ажлыг төдийгүй түүнээс ч илүү агуу ажлуудыг хийнэ гэсэн байдаг. И Жей руг пастор нь Ариун Сүнсний багаж

болж бүх дэлхий даяар Бурханы хүч чадлыг харуулж байгаа билээ. Пасторын амьдрал дэлхийн өнцөг булан бүр дэх хүмүүсийг өөрчилж, үй олон эдгэрлийн хүч нөлөө гарч байгаа юм.

Зөвхөн итгэлээр бий болсон үйлчлэл болохыг Ариун Сүнсний үр жимс харуулж байна. Даруухан болоод хүн төрөлхтөнийг маш их хайрлах сэтгэлээр Ариун Сүнсний хүч нөлөөг агуу ихээр гаргаж байгаа юм. Пастор бол энэ эцсийн үед дэлхий даяарх бүх хүмүүс рүү хандсан авралын үүргийг хариуцсан гэж бодож байна.

Миний хүсэл мөрөөдөл ч анагаах ухаанаар маш олон газар салбар байгууллага бий болгож WCDN үйлчлэлийг танилцуулж, хүмүүс төдийгүй анагаах ухаан, шинжлэх ухааны салбарт Бурханы үг хэрхэн нөлөөлдөгийг харах болно. Мөн энэ үйлчлэлээр дамжуулан энэ цаг үеийнхэнд ч итгэл бол үндэс суурь гэдгийг мэдүүлэх хүсэлтэй юм.

Ингэж WCDN-ны агуу үйлчлэлтэй хамтдаа байх боломжыг өгсөн үнэхээр их баярлалаа. Манминтай хамтдаа ажиллаж, энэ авралын мессежид оролцох боломжыг өгсөнд баярлалаа.

Мөн эдгэрэх найдлагагүй төрөл бүрийн өвчнөөс эдгэрсэн итгэгч нарын гэрчлэл маш байна. Конго бүгд найрамдах улсын Нгүн жа итгэгч (60, эм) болон Энэтхэг Лиси Сирибас таб (2, эр) зэрэг залбирал авсаны дараа дох өвчнөөсөө эдгэрч, Монгол Ундрах итгэгч (64, эм), Ким Сүн жа туслагч (74, эм) паркинсоны өвчнөөсөө эдгэрсэн бол Герман Ребека итгэгч (50, эм) ясны хорт хавдраас эдгэрч, Жу Сү гён сүмд үйлчлэгч (42, эм) тархины бүх хэсэгт тархсан тархины хавдар, Жу Гён а халамжлагч (52, эм) Дотор чихний эмгэг чихний булаг гоожих, Ким Хе өн эгч дүү (28) хоолны дуршил буурах өвчин, Шин Дун хуа сүмд үйлчлэгч (61, эм) 50жилийн дараа шээс задгайрах өвчнөөсөө залбирал аван тус тус эдгэрцгээсэн юм.

И Жэ жин ах дүү (21) тархи нугасны үрэвсэлийн улмаас дунд сургуульд байхдаа өндөр 128см байсан бөгөөд И Жей

руг пасторын залбирал авч өсч эхэлсэн ба 38см өсч одоо 166см өндөртэй хэвийн амьдралтай болсон.

Мөн Чүэ Хэ сүг туслагч (58, эм), Малайз Чү Пон пин (44, эм) Энэтхэг Кита итгэгч (42, эм) муу сүнсний нөлөөнөөс чөлөөлөгдөж баяр хөөрөөр дүүрэн шинэ амьдралаар амьдарч байгаа Колумби Ангелика Осиро итгэгч (19, эм) олон жил шаналж байсан ганцаардлын өвчнөөсөө эдгэрсэн юм.

Банкны баталгааны гэрээнд гар үсэг зурсанаар асар их ерийн дарамтанд шаналж эхнэртэй амиа хорлох хүртэл оролдлого хийж байсан И Дун сон сүмд үйлчлэгч (80, эр) болон маш олон төрлийн өвчинд зовиурлаж амиа хорлохоор гэрээсээ гарч явсан Куан Сог жүн (68, эр) манай цуглаанд ирээд өвчнүүдээсээ салж, Ариун Сүнсний бялхал итгэлээр амьдарч аз жаргал баяр хөөрөөр дүүрэн хүмүүсийн тоолох аргагүй олон юм.

## УБ Ариун баярт мэдээ чуулган

### Мөргөлийн цагийн хуваарь

### залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10:30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11:30			
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21:30			
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09:00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15:00			
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17:00			

### Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан: power3712@gmail.com

‘Сүнслэг хайр’ – 8

## Хайр бол өөрийнхнийг эрдэггүй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй. Зохисгүй авирладаггүй, өөрийнхнийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.”

1 Коринт 13:4-5

### И Жей руг тэргүүн пастор

Өнөө үе бол бусад ямар ч үеэс илүү бусдын эрх ашгийг хайдаг сүнслэг хайр туйлын хэрэгтэй цаг үе болоод байна.

Нярай хүүхдийн нэмэлт тэжээлийн найрлагад хортой химийн бодис орсон бол зөвхөн хувийн эрх ашгийн төлөө нэр төрөө чухалчилж, өөрсдийн технологийг нууж байгаад асар их хэмжээний хохирол амссан тохиолдлыг харж болно. Энэ мэт хэт туйлдаа хүрсэн явдал биш ч гэсэн бидний өдөр тутмын амьдралд өөрийн эрх ашгийг түрүүлж харж байна уу эсвэл бусдынхийг харж байна уу гэдгийг амархан харж болно.

#### 1. Бусдын эрх ашгийг хайдаг сүнслэг хайр

Жишээлбэл ажлын хамт олон, эсвэл найз нөхөдтэйгөө гадуур хооллохоор явахад хүн болгоны санал өөр байдаг. Зарим хүн дахин дахин өөрийн идэхийг хүсэж байгаагаар тулгадаг байхад, зарим нь бусад хүмүүсийн хүссэний дагуу хамт явдаг сэтгэл баяртай биш байдаг.

Хурлын үеэр ч өөрийн саналыг дэмжүүлэхийн тулд бусдыг ятгадаг хүн байдаг бол өөрийн үзэл бодлоо хүчтэй илэрхийлдэггүй ч бусдын саналд нийцтэй тааламжтай байдаггүй хүн ч бий. Эсрэгээрээ бусад хүмүүсийн саналыг чих тавин сонсож, хэдийгээр өөрийн санал бодлоос нь өөр байсан ч дагаж өгдөг хүн ч байдаг. Ийм ялгаатай талууд нь хүн тус

бүрийн зүрх сэтгэлд хэр зэрэг хайр байгаагаас шалтгаалж байдал өөрчлөгддөг.

Хэрэв санал бодлын зөрчилдөөн даамжирч маргалдахад хүрч хоорондоо эв түнжин хагарвал зөвхөн өөрийн байр сууриар л зөрүүдлэн өөрийн ашгийг хардаг учраас юм. Нэгдэж хайрлах ёстой эхнэр нөхрийн хооронд ч өөрийнхөөрөө зөрүүдэлбэл байнга зөрчилдөж ойлголцож чадахгүй байдалд хүрдэг. Бие биедээ найр тавин бусдын үүднээс бодвол хичнээн л бол эвтэй хийчих юмыг өөрийнхөөрөө зөрүүдлэх учраас түнжин хагардаг.

Бусдыг хайрладаг бол үргэлж өөрөөсөө илүү бусдыг боддог. Ихэнх эцэг эхчүүд өөрөөсөө илүү үр хүүхдээ боддог “Аав ээжийгээ дуурайсан хөөрхөн хүүхэд” гэхээс илүү “Аав ээжээсээ илүү хөөрхөн ухаантай” гэдэг магтаалд илүү дуртай байдаг. Өөрөө амттай сайн зүйл идэхээс илүү хүүхдэдээ идүүлэх маш дуртай. Өөрөөсөө илүү үр хүүхдэдээ сайн хувцас өмсүүлэх гэж өөрөөсөө илүү ухаалаг, боловсролтой, илүү хүлээн зөвшөөрөгдөж хайрлагдахыг хүсдэг. Бид ийм хайрыг бүх хүмүүст өгвөл Бурхан хичнээн баярлах бол?

#### 2. Хайраар бусдын эрх ашгийг хайдаг Абрахам

Өөрийн хүсэл сонирхолоос илүү бусад хүний эрх ашгийг харна гэдэг харамгүй золиос гаргаж чадах хайрын сэтгэлээс үүдэлтэй.

Үргэлж өөрийн эрх ашгийг хайлгүй бусдынхыг боддог хүнээр Абрахамыг нэрлэж болно.

Эхлэл номын 13-р бүлэгт Абрахам болон түүний дүү Лотын тухай гардаг. Абрахам төрөлх нутгаасаа гарах үед Лот хамт явсан бөгөөд тэрээр Бурханы хайрыг авсан Абрахамтай хамт байсан төдийд ерөөл авсан юм. Түүний эзэмшил эд хөрөнгө арвижиж, алт мөнгө төдийгүй, маш их мал сүрэгтэй болсон тул мал услах уснаас болж Абрахам болон Лотын малчид хоорондоо маргалдах хэмжээнд хүрсэн юм.

Абрахам эв түнжин хагарахыг хүсээгүй тул эхлээд Лотод сонго эрхийг өгсөн юм (Эхлэл 13:9). Канаан хил хязгаар нутаг ус бэлчээр хангалттай байхгүйн улмаас цаашид бэлчээртэй газар оторлон нүүх газрыг түрүүлж сонгох эрхийг өгнө гэдэг нь амиа өгөхтэй ижил юм. Тэр хэмжээгээр Абрахам дүү Лотыг хайрладаг тул ингэж чадсан юм. Тийм болохоор Лот ус бэлчээр арвин Иорданы хөндийг сонгон нүүсэн юм.

Тэгвэл өөрийн эрх ашгийг даган түрүүлж Иорданы хөндийг сонгон нүүсэн Лотыг харахдаа Абрахамын сэтгэл бухимдсан болов уу? Тэгээгүй юм. Абрахам үнэхээр дүүгээ өөрөөсөө илүү сайн газарт очсонд баяртай байсан юм.

Абрахамын үүднээс бодоод үзвэл Лот нь өөрийнх нь хүчээр ерөөгдсөн ба дэг журам нас намбаа

бодвол ахмад хүн тул түрүүлээд сонгох байсан юм. Тэгтэл тэрээр чин сэтгэлээсээ илүү сайн газар сонгохыг хүссэн тул Лоттой эвтэй байж ба Бурханаас илүү том ерөөл авсан юм. Эд хөрөнгө эрх мэдэл нь хичнээн том болохоороо эргэн тойрны хаадууд хүртэл түүнийг хүндэтгэж, тэр мөн сайхан сэтгэлийн улмаас Бурханы анд нөхөр дуудагдах болсон юм.

Энэ мэт бүх зүйлд бусдын төлөө байдаг хүн бусдын сэтгэлийг бодож, нийцүүлж өгдөг тул зайлшгүй Бурханы ерөөлийг авдаг. Хайртай нэгнийхээ төлөө өөрийн зүйлээ өгнө гэдэг нь ямар ч баяр ч хөөрөөс илүү юм. Есүс ч энэ мэт дээд зэргийн баяр хөөрийг эзэмшсэн юм.

### 3. Дээд зэргийн аз жаргалыг эдлэхийн тулд

Бид ч гэсэн төгс хайрыг бий болговол дээд зэргийн баяр хөөр аз жаргалыг эдлэх юм. Есүс шиг дээд зэргийн баяр хөөр аз жаргалыг эдлэхийн тулд цаг үргэлж өөрөөсөө илүү эргэн тойрноо боддог байх ёстой юм.

Надаас илүү хөршөө, надаас илүү Бурхан ба Эзэн, сүм чуулган нэн түрүүнд байх ёстой юм. Гэр бүлдээ ч надаас илүү гэр бүлээ гэсэн сэтгэлээх эргэж харах ёстой юм. Ийм хүнийг Бурхан харж өгдөг. Бид бусдын эрх ашгийг хайх үед Бурхан зайлшгүй илүү сайн зүйлсээр буцааж өгдөг.

Тиймээс өгөх нь авахаасаа илүү ерөөлтэй гэсэн байдаг (Үйлс 20:35). Тэгэхдээ энэ ишлэлийг буруу ойлгож болохгүй. Итгэмжтэйгээр үйлчилж байна гээд хэтрүүлж эрүүл мэндийн хувьд доройтож болохгүй биз дээ. Өөрийн

хэмжээнээс илүү үйлчлэх сэтгэлийг Бурхан баяртайгаар хүлээн авах ч заримдаа биеэ амрааж байх ёстой. Мөн залбирч, сургаал уншиж сонсох цагийг гаргаж өөрийн сүнсний өсөлтөө бодолцох ёстой.

Хааяа сүмийн ажилд автан гэр бүлийнхэн болон эргэн тойрныхоо хүмүүст хохирол учруулдаг хүмүүс байдаг. Мацаг барин хүчгүй байна гээд ажилдаа явахгүй байх, сүмийн ажилд хичээж байна гээд гэрийнхээ хүмүүсийг тав тухыг алдагдуулдаг. Сүм дээ үйлчлэх сайхан гээд гэрийн эзэгтэй хүн сүмийн ажилдаа улайрвал, сурагч хүн хичээлдээ анхаарахгүй мөртлөө цуглаанд идэвхитэй байдаг.

Энэ тохиолдолд өөрөө тоглохгүй амраагүй, өөрийн ажлыг бодоогүй гэдэг ч яг ярих юм бол өөрийн эрх ашгийг бодсон явдал юм. Эзэний өдөр итгэмжтэй үйлчилсэн ч гэртээ юмаа хийгээгүй тул Бурханы хүүхдийн хувьд үүргээ гүйцэтгэлээ гэх боломжгүй юм. Өөрийн хийх ёстой дуртай ажлаа хичээнгүйлэн хийдэг ч мэдээж хийх ёстой өөр хэсгийг хийгээгүй байна гэсэн үг.

Бид бүх зүйлд өөрийн эрх ашгийг хайхгүй байхын тулд Ариун сүнсний тусламжыг авах ёстой юм. Ариун Сүнс нь Бурханы сэтгэл тул биднийг үнэн дотор удирддаг (Үйлс 16:13). Тийм ч учраас Ариун Сүнсний удирдамж дагаад хийвэл юу ч хийсэн Бурханы алдрын төлөө амьдарч чаддаг.

Энэ мэт Ариун Сүнсэнд түшиглэж, Ариун Сүнсний удирдамжыг авахын тулд юуны өмнө зүрх сэтгэл дэх хорон мууг хаях явдал юм. Бүр цаашлаад зүрх сэтгэлдээ сүнслэг хайрын бий болговол нөхцөл байдлаасаа

сайны мэргэн ухаан бууж ирж Бурханы хүслийг ухаарч чаддаг. Сүнс сэтгэл сайжрахын сацуу ажил үйлс сайжирч, эрүүл энх эрч хүчтэй үйлчлэх боломжтой. Тиймд Бурханы хүүхдийн хувьд итгэгч бус хөршөө, гэрийнхнээ хайрыг авахын тулд өөрийн эрх ашгийг хайлгүй бусдынхыг хайх хэрэгтэй юм.

Хайрт итгэгч та бүхэн, Бурхан бусдын эрх ашгийг л хайдаг хайр төдийгөөр зогсохыг хүсэхгүй хайртай хүн, тусламж хэрэгтэй хүн төдийгүй зовоодог, хохирол учруулдаг, хүнийг ч гэсэн түүний ч эрх ашгийг түрүүлж бодолцож өгдөг байх ёстой юм.

Хэрвээ өөрийг нь зовоодог хүнтэй таарах үед холдох зайлсхийх, дургүйцэх мэдрэмжтэй бол хараахан өөрийн эрх ашгийг бодох сэтгэл байгаа болохыг ухаарах хэрэгтэй. Хүнд нөхцөлд ч өөрөөсөө огт өөр хүнтэй уулзлаа ч эхлээд түүний өмнөөс бодож өгч золиослодог байж сүнслэг хайр гэх юм.

Өөртэй нь нийцээгүй байсан ч хайрлаж, зориулж өгснөөр бусдын үүднээс боддог болохыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

---

Сөөл хот, Гүүр дүүрэг, дижитал-26-29 тоот  
152-848 Солонгос Улс  
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048  
<http://www.manmin.org/english>  
[www.manminnews.com](http://www.manminnews.com)  
e-mail: [manminninen@manmin.kr](mailto:manminninen@manmin.kr)  
Нийтлүүлэгч: Жаерок Лее


## Монгол Манмин Сүм

### Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

### Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00





## “Амьд оршигч Бурхантай уулзаж, мэдэрсэн итгэлийн амьдрал, жаргалтай байна”

Ом Жон хи халамжлагч (55нас, 2-р их бүлэг 11-р хэсэг)

2017оны 3-р сард эрүүл мэндийн шинжилгээнд орсон холестерин ихтэй зүрхээр базлах ба судасны ханы өөхлөлттэй байна гэсэн юм. Энэ хугацаанд итгээр амьдарч маш олон эрх мэдэлт хүчний нөлөөг үзэс мэдэрсэн болохоор нээх санаа зовоогүй юм. Харин итгэлээрээ эдгэрэхийн төлөө мөн хичээнгүйлэн үүргээ гүйцэтгэж сүнсээр өсөж өөрчлөгдөхийн төлөө хичээнгүйлэн залбирч байлаа.

Нүдний хараа 1.0, 1.5 байсан ч дараа нь 0.8, 1.0 болж муудаж юм уншихад давхардаж харагдаад цилиндртэй нүдний шил л хэрэглэдэг болсон нь маш тавгүй байлаа. Тэгээд мөргөлд суух болгонд нүдэндээ гараа хүргэн И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээн залбирлыг чин сэтгэлээсээ авч байлаа. Ялангуяа Манмин зуны цуглаан, Манмин залбирлын газрын эдгэрэл ивээлийн цуглаанд оролцон ивээл хариулт сайхан боломж ирвэл бүх зүрх сэтгэлээрээ бэлтгэн оролцдог байв.

### Хараа 2.0 болж сайжирч судас хатуурч өөхлөх өвчин эдгэрсэн нь

Саяхан би үнэхээр гайхалтай мэдрэмжийг хүртсэн юм. 2018оны өвлийн эхээр Даниел залбирлын үеэр дууны нот харж магтаал дууны үгийг дуудаж өгдөг үйлчлэл хийж байх зуур үсэг маш тод харагдаж эхэлсэн юм.

12-р сарын 14ны өдөр эмнэлэгт шинжилгээ өгч, хараагаа шалгуултал хараа шалгах үсэг маш тод харагдсан. Гайхалтай нь нүдний хараа минь 2.0 болсон байлаа. Илүү талархалтай зүйл нь нүдний болор цайх муудах шинж маш их сайжирч нүдний шилгүй ном уншдаг болсон юм.

Мөн төдийгүй холестерин хэмжээ хэвийн болж, судасны хатуурал эдгэрч бүр зүрхний титэм судасны байдал миний настай харьцуулбал 5н насаар залуу гарсан юм. Халлелүяа!

Дахин нэг удаа Бурхан Аавын хайрыг мэдрэн өнгөрсөн өдрүүдээ эргэн харахад Бурханд хамаарах эрх мэдэлт хүчний нөлөөг сүмд анх ирсэн цагаас мэдэрч ирсэн юм.

1990оны 9-р сард тухайн үед нурууны диск архагшсан учраас сайн алхаж чадахгүй дотор давчддаг байлаа. Янз бүрийн эмийг удаан

хугацаанд уугаад эдгээгүй ч хамт ажилдаг хүнийхээ танилцуулгаар баасан гаригийн оройн мөргөлд оролцоод эдгэрсэн юм.

Тэр өдөр тэргүүн пастор сургаалийн дараа өвчний төлөө залбирал хийж өгөхөд “Өвчтэй газраа гараа тавиад залбирал авахыг хүсье” гэсэн юм. Тэгэхэд би нуруу нь дээрээ гараа тавиад залбирал авахад нурууны өвчин хөндүүр өргөс авсан мэт зүв зүгээр болсон юм. Түүнээс хойш нуруу минь огт өвдөөгүй юм. Халлелүяа!

### Бурханы үгээр өөрчлөгдөн гэр бүлээрээ итгэгч болон

Би Бурханы хүч чадлаар хүнд хэлбэрийн нурууны диск өвчнөөсөө нэг дор шууд эдгэрсэнээс хойш яг тэнгэрт нисэх мэт болж Эзэний хайраар бялхаж байлаа. Тэгээд амралтын өдрийг ариунаар сахиж, ямар нэг зүйлийг Эзэнд өргөмөөр санагдаж арун хоор дуу, магтаал дууны багт үйлчилсэн юм.

Тэгээд 1994онд авга эгчийнхээ танилцуулгаар би хүнтэй суусан юм. Хуримаа хийчээд нөхөр маань надтай хамт сүмд явна гэж бодож байтал нөхөр маань хадам ээжтэй хамт сүмд явахыг минь маш хүчтэй хорьж байлаа. Бүр хавчлага ихсэх тусам би мөргөл дээр сонссон сургаалиа сэтгэлдээ шингээн үйлдэж, эхнэр хүний хувьд бэрийн хувьд хайраар үйлчлэх гэж хичээсэн юм. Эцэст нь нөхөр минь сэтгэлээ нээж сүмд ирдэг болж, хадам ээж маань ч бага багаар надад итгэж өгсөнөөр Эзэнийг хүлээн авсан юм.

2001оны 9-р сард би нөхөр болон хадам ээжтэйгээ хамт тэргүүн пасторын ивээлээр түүний удирдах ‘Филиппин нэгдсэн их цуглаан’-ны индэр Есүл магтан дууны багт сөвүүрт бүжгээр өргөх боломж олдсон юм. Тухайн үед үйл ажиллагаа болох гэж байгаа газар далай хар шуурга ойртож байгаа мэдээ гарч нэгдсэн их цуглааны өмнөх хэвлэлийн бага хурал дээр сэтгүүлчид “Далай хар шуурга ойртож байгаа болохоор гадаа талбай танай үйл ажиллагаа явагдах хэвээрээ юу?” гэж тэргүүн пастораас асуусан юм. Тэгтэл тэргүүн пастор “Далай хар шуурга сарних юм уу, чиглэлээ өөрчлөх бөгөөд манай үйл ажиллагааны үеэр хамгийн таатай цаг агаар

байх болно гэдгийг та бүхэн харах болно” гэсэн юм.

Яг тэр үгийн дагуу далай хар салхи чиглэлээ өөрчлөн эсрэг тийшээ чиглэсэн бөгөөд нэгдсэн их цуглааны үеэр цаг агаар маш цэлмэг сайхан байдалд явагдсан юм. Мөн нэгдсэн их цуглааны үеэр ухаангүй болж саажгаад үхсэн мэт болсон нэгэн залууг тэргүүн пастор дээр авчирч тэрээр залбирч өгөхөд газар дээрээ босч, дамнуурга дээр ирсэн өвчтнүүд босч алхдаг болсон зэрэг эрх мэдэлт хүчний нөлөө гарч буй бодит талбар дээр байхдаа тэдгээрийг харж улам их итгэлээр өсөх боломж болсон юм.

2004оны 12-р сард ‘Перу нэгдсэн их цуглаан’-ны бэлтгэл ажилд оролцон 40хоногийн турш Перуд байж уг үйл ажиллагааны суртчилгааны ажилд үйлчлэх гэх сайхан дурсамж байна.

Одоо ч гэсэн нөхөр ба охин маань би чухал ажил хийдэг маш их тусалж дэмждэгт маш их баярлаж байна. Одоо хэсгийн дэд ахлахын хувьд хариуцсан хүмүүстээ анхаарал тавьж, Бурхан Аавын хайрыг улам олон хүмүүст дамжуулахыг төлөө хичээсээр ирсэн юм.

Өнгөрсөн 30жилийн турш Манмин төв сүмд итгэлээр амьдран би өдөр өдрийг аз жаргалаар дүүрэн байлаа. Бурхан яг л надад “Би энд байна” гэдэг амьд оршиж буй баталгааг үргэлж үзүүлж өгч, мөн төдийгүй гуйснаас минь илүүгээр маш олон хариулт болон ерөөлийг авсан юм.

Юу юунаас илүү Бурханы хайр ба үзэсгэлэнтэй тэнгэрийн орны тэмүүлэлээр сэтгэл хөдлөм ерөөлийн өргөө сүм рүү удирдаж өгч вуг ч гэсэн миний хүссэнээс илүү бялхтал өгдөг үнэнч шударга Ариун гурвал Бурхандаа алдар талархалыг өргөө.

### Эрүүл мэндийн шинжилгээний хариу:

수축기 혈압(mmHg)	88/64	키 (cm) 및 몸무게(kg)	173 / 65
이완기 혈압(mmHg)	58/40	체질량지수(BMI)	21.3
심박수(회/분)	72	혈당(FPG)	87
시력(시력)	1.0 / 1.5	시력(시력)	2.0/2.0
혈색소(g/dL)	13.3	정장/정장	
공복혈당(mg/dL)	88	혈색소(g/dL)	12.9

Залбирал авсаны дараа зүүн талынх 3-р баруун талынх нь 1-р хараа сайжирсан нь.